

ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ/ INTERIM STATEMENT

Монголиан Эйрвэйс ХХК-ийн AS350 B3 Нисдэг тэрэгний осол

Энд өгсөн мэдээлэл нь түр зуурын шинж чанартай. Эцсийн тайланг нийтлэхээс өмнө шинэ мэдээлэл гарч болзошгүй.

MGW1431 аялалын дугаартай H125 маягийн, JU6888 улсын бүртгэлийн дугаартай нисдэг тэрэг нь 2022.09.25-ны 07.47 цагт Улаанбаатар хот Баян-Зүрх дүүрэг, Гацууртын Хар Усан тохойгоос хөөрч Лүн сумын районд 08.26 цагт буулт үйлдэхээр тооцоолсон байна. Уг нисдэг тэрэг нь 07.56 цагт Буянт-Ухаа аэродромын Цамхагийн НХУ-ын 132.7 МГц давтамж дээр холбоонд орж тус Аэродромын хариуцлагын бүсэд орох зөвшөөрөл аваад ил хараагаар нислэг үйлдэн 08.01 цагт зурвасны чиглэлд хөндлөн нисэж 08.04 цагт Буянт-Ухаа аэродромоос 10 км орчим холдож радио холбоо завсарлан цааш нислэг үйлдэж эхэлсэн бөгөөд Төв аймгийн Аргалант сумын нутаг Улаанбаатараас 78 км зайд 8.20 цагт хээрийн буулт үйлдэх үедээ осолдсон байна.

Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1. дэх заалт, ЗТХ Сайдын 2018 оны 08 дугаар сарын 09 өдрийн 171 тоот тушаалаар батлагдсан Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 2.2. заалтыг үндэслэн НТОЗШША-ны даргын тушаалаар томилогдсон баг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэлээ. Үйл явдал болсон газар дээрх нөхцөл байдал, Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт болон Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн уг нислэгийн тохиолдлыг агаарын хөлгийн ослын ангилалд бүртгэв. Агаарын хөлгийн хөөрөлтийн дээд жин 2250 кг боловч нислэгийн тохиолдлыг осол гэж ангилсан тул Чикагогийн конвенцийн 13-р Хавсралтад заасны дагуу агаарын хөлгийн зохион бүтээгч, үйлдвэрлэгч улсад мэдээллэх шаардлагатай гэж үзсэн. Агаарын хөлгийг зохион бүтээгч нь Франц улс, үйлдвэрлэгч нь Франц улс, Бүртгэсэн улс нь Монгол, ашиглагч нь Монгол улс байгаа тул ослыг шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13-р Хавсралтад заасны дагуу мэдэгдэж хамтран ажиллаж байна.

25 SEP 2023